

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Жаргалан-Алтай" Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/175/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Б.Батбаатар
Утас: 89593311 Цахим хаяг: batbaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.19 № 31

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Жаргалан-Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Жаргалан-Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өрхийн эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ноогдох норматив зардлаар болон 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжилт авдаг байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоолоор өдрийн эмчилгээ, сэргээн засах эмчилгээ, гэрээр үзүүлсэн тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээний тариф нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80.0 хувийг сар бүрийн 10-ны дотор авахаар, 20.0 хувийн санхүүжилтийг 14 шалгуур үзүүлэлт хангасан тохиолдолд олгохоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нэг иргэнд ноогдох нормативд зардал 53,982.7 мянган төгрөг, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 404,638.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд "Жаргалан-Алтай" өрхийн эрүүл мэндийн төв нь аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газартай гурван талт гэрээ байгуулан ажиллаж гэрээнд заасан үүргээ 84.6 хувь биелүүлсэн байна. Мөн өрхийн эрүүл мэндийн төв нь 6 зорилтын хүрээнд 22 арга

07020137

хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгаж, биелэлтийг 91.6 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	51,516.8	61,989.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	58,881.3	70,924.0
Нийт хөрөнгийн дүн	110,398.2	132,913.9
Нийт өр төлбөрийн дүн	0.00	3,491.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	110,398.2	129,421.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	110,398.2	132,913.9
Үйл ажиллагааны орлогын дүн	613,776.6	509,000.5
Үйл ажиллагааны зардлын дүн	615,144.7	489,976.8
Үйл ажиллагааны үр дүн	(1,368.1)	19,023.7
Үйл ажиллагааны бус үр дүн	0.00	0.00
Үйл ажиллагааны нийт үр дүн	(1,368.1)	19,023.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	111,766.3	94,147.8
Тайлант оны үр дүн	(17,618.4)	19,023.7
Эцсийн үлдэгдэл	94,147.8	113,171.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	575,155.2	431,630.4
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	551,487.5	406,146.7
Үйл ажиллагааны ЦМГ	23,667.7	25,483.4
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(25,193.0)	(25,617.8)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(1,525.2)	(134.3)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,685.5	160.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	160.2	25.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	0.0	0.0
Урсгал зардал	0.0	0.0
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	0.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	0.0	0.0
Улсын төсвөөс санхүүжих	0.0	0.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.0	0.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Залруулагдаагүй нийт 0.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 0.9 сая төгрөгийн 1 зөрчил¹ илэрснээс, 1 зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Сахилгын шийтгэлтэй 3 ажилтанд 0.9 сая төгрөгийн урамшуулал олгосон байгаа нь “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, 123.9-т “Ажил олгогч энэ хуулийн 123.8-д заасан хугацаанаас өмнө ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцож болох бөгөөд энэ тухай ажилтанд бичгээр мэдэгдэнэ” Хөдөлмөрийн дотоод журмын 1.9.1-т

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"Сахилгын шийтгэлийг хамт олны хурлаар хэлэлцүүлж, төвийн даргын тушаалаар ногдуулах ба сахилгын шийтгэл хүчинтэй үйлчлэх хугацаа буюу календарийн 1 жилийн хугацаанд тухайн ажилтанд үр дүнгийн нэмэгдэл, шагнал урамшууллыг олгохгүй хасаж тооцно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллыг сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд олгохгүй байх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/									
			Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
"Жаргалан-Алтай" Өрхийн эрүүл мэндийн төвийн	1	0.9	-	-	1	0.9	-	-	-	-	-	-
Дүн	1	0.9	-	-	1	0.9	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-